



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№196 /406/

2022.11.01

Цаг үе, үйл явдал

МЭРГЭЖЛИЙН ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГАРДАН АВЛАА



Өнөөдөр ҮБХИС-ийн Сүбээдэй танхимд РЛС-ын операторчин болон планшетчины мэргэшүүлэх 45 хоногийн шаталсан сургалтад хамрагдаж, амжилттай дүүргэсэн бие бүрэлдэхүүнд гэрчилгээ гардууллаа.

Төгсөлтийн арга хэмжээд ҮБХИС-ийн ЦНДС-ийн Агаарын цэргийн тэнхимийн дарга хурандаа Б.Ганзам, Сургалтын хэлтсийн дарга хурандаа Б.Батмөнх, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын ахлах мэргэжилтэн Ч.Буянзаяа тэргүүтэй удирдлагын бүрэлдэхүүн, сургалтад хамрагдсан алба хаагчид оролцлоо.

ҮБХИС-ийн ЦНДС-ийн Агаарын цэргийн тэнхимийн дарга хурандаа Б.Ганзам хэлэхдээ “Зэвсэгт хүчний АДХЦ-ийн командын болон инженер, техникийн бүх төрлийн мэргэжилтнүүдийг 1990 оны эхэн үе хүртэл зөвхөн ЗХУ-ын цэргийн академи, дээд, дунд сургуулиудад бэлтгэж байлаа. 1990 онд ЗХУ-д өөрчлөн байгуулалт явагдаж эхэлснээс үүдэн манай улс АДХЦ-ийн мэргэжилтнээ дотооддоо бэлтгэх шаардлага тулгарсан байдаг. Ийнхүү Батлан хамгаалахын сайдын 1991 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар Цэргийн их сургуулийн

Артиллерийн тэнхимд Зенит, Холбооны тэнхимд Радиотехникийн секторыг нэмэн оруулж, тэдгээр тэнхимүүдийн нэрийг Артиллери-ЦАДХ-ын, Холбоо-радиотехникийн тэнхим болгон өөрчлөн баталснаар АДХЦ-ийн тэнхим байгуулагдах анхны суурь тавигдсан юм. Энэхүү тэнхимийн 30 жилийн ой энэ жил тохиож байгаа бөгөөд бид энэхүү ойг угтсан олон бүтээлч ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа юм. Түүний нэг нь АЦК-ын харьяа анги, салбарын бага мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор РЛС-ын операторчин болон планшетчины мэргэшсэн

алба хаагчдыг бэлтгэх шаталсан дамжаа юм. Тус дамжаа нь ҮБХИС-ийн Агаарын цэргийн тэнхимийг түшиглэн 45 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулагдаж, сургалтад хамрагдсан алба хаагчид гэрчилгээгээ гардан авч байна. Мөн өнөөдрөөс эхлэн ҮБХИС-ийн Агаарын цэргийн тэнхимийг түшиглэн АЦК-ын рот, баттерейны захирагчийн дамжаа, нисдэг тэрэгний хөдөлгүүрийн механикчийн дамжаа, зенит, артиллерийн бууны даргын дамжаа тус тус хичээллэж эхэлнэ” хэмээсэн юм.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 1	☁️ -14

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,412	3,418
EUR 🇪🇺	3,395	3,430
CNY 🇨🇳	464	469
RUB 🇷🇺	52.20	52.26
JPY 🇯🇵	23	23.40
KRW 🇰🇷	2.40	2.44

ЗУРХАЙ

2022.11.01 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 8

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна

Наран ургах, шингэх:

07.36-17.37

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

“АЛЖААЛ ТАЙЛСАН АМРАЛТЫН НЭГ ӨДӨР”- ӨӨР ...



Монгол Улсын Зэвсэгт хүчинд Цэргийн сургалт бэлтгэлийн алба байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд олон бүтээлч ажлыг зохион байгуулж байна. Үүний нэг нь өнгөрсөн амралтын өдөр “Багабаян-Энхийн төлөө цогцолбор”-т зохион байгуулсан өдөрлөг бөгөөд “Эрүүл агаар-эм” сэдэвт уг өдөрлөгт ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн

нийт бие бүрэлдэхүүн хамрагдлаа. Өдөрлөгийн нээлтийн ёслолд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах оролцож хэлсэн үгэндээ “Ажлын ачаалал ихтэй байдаг Та бүхэн нэгэн өдрийн турш эрүүл агаарт гарч, алжаалаа тайлахын хамт нөхөрсөг уулзалт ярилцлагыг өрнүүлэн Сургалт бэлтгэлийн газраас зохион байгуулах уралдаан тэмцээнд амжилттай оролцоно гэдэгт итгэл төгс байна.

Энэхүү өдөрлөгийн эцсийн зорилго нь багаар ажиллах чадвар, хамт олноо үлгэрлэн дагуулах, нийтэч уур амьсгалыг бүрдүүлэх өндөр ач холбогдолтой юм” гэдгийг онцлов.

Энэхүү өдөрлөгийн эхэнд асуулт хариултын “АХА” тэмцээнийг зохион байгуулсан ба уг тэмцээнд өдөрлөгт оролцож буй нийт офицер, ахлагч, ажилтнууд идэвхтэй оролцсоноос ЗХЖШ-ын Материал, техникийн газрын хэлтсийн дарга хурандаа С.Баяр-Очир тэргүүлж, тус газрын Техникийн хэлтсийн ерөнхий инженер, ахлах мэргэжилтэн дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга хурандаа Ж.Өсөхбаяр нар удаалав.

Үүний дараа “хүмүүн төрөлтөн”, “задгай цагаан”, вальс, вальс бостон, танго зэрэг төрлөөр явагдсан “Нийтийн цэнгээнт бүжгийн тэмцээн”-д Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр, Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор нар тэргүүн байр, БСТГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа М.Батболд, ХШУГ-ын нууцын дарга, архивын эрхлэгч сургагч ахлагч Ч.Тэгшжаргал нар дэд байр, Хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн ахмад

Н.Амарбаясгалан, Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн ахмад Ч.Ганчулуун нар гутгаар байрыг эзэлсэн юм.

Мөн хамт олны дунд гэрэл зургийн уралдааныг нээлттэй зарлаж, албан тушаалтнууд туйлын идэвхтэй оролцсоноос Хэвлэл мэдээллийн албаны мэргэжилтэн хошууч Ц.Пүрэвдоржийн ирүүлсэн “Бүжгийн өрсөлдөөн” сэдэвт гэрэл зураг тэргүүн байрын шагналыг хүртэж, Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн М.Лачингаравын “Цэнгэг агаарт чөлөөт бүжгээр цэнгэхүй” зураг дэд байрыг эзэлснээс гадна Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаярын “Бодрол” бүтээл гуравдугаар байрт шалгарлаа.

Уг өдөрлөгийн үеэр зохион байгуулсан уралдаан тэмцээний шагнал нь Сургалт бэлтгэлийн газрын 100 жилийн ойн бэлгэдэл бүхий дурсгалын зүйл болон оюуны үнэт зүйл лбох ном байсан нь бас л нэгийг бодогдуулж билээ.

Түүнчлэн уг өдөрлөгийн үеэр явагдсан бүхий л ажиллагаа, торгон агшныг илтгэсэн гэрэл зургуудаар үзэсгэлэн гаргасан нь шинэлэг байсныг зохион байгуулагчид төдийгүй оролцогчид онцлов.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 635,706,776

Эдгэрсэн

Нийт: 614,987,981

Нас барсан

Нийт: 6,594,723

Цаг үе, үйл явдал

ШИНЭ ДАЙЧДЫН СУРГАЛТ АМЖИЛТТАЙ



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2022 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан дайчдын цэргийн анхан шатны сургалт, бэлтгэлийг амжилттай зохион байгуулж байна.

Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагчдад

“Цэргийн албаны онцлог, түүнд дасах нь”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, “Хугацаат цэргийн алба хаагчийн эрх, үүрэг, хариуцлага”, “Цэргийн сахилгын дүрэм”, “Сэтгэл зүйч гэж хэн бэ” зэрэг сэдвээр онолын мэдлэгийг олголоо.

Мөн хугацаат цэргийн

алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Тэргүүний шилдэг салаа” шалгаруулах уралдааныг зарлаад байна.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА

ШИНЭ ДАЙЧДЫН ТӨРСӨН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭВ



Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж 2022 оны хоёрдугаар ээлжээр Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар ангид татагдан алба хааж буй шинэ дайчдын төрсөн өдрийг Танкын батальон, Хүнсний албатай хамтран тэмдэглэлээ.

Төрсөн өдрийн арга хэмжээнд Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудаас цэргийн албанд татагдсан, 10 дугаар сард төрсөн 16 байлдагч оролцож инээд баяслаар дүүрэн нэгэн өдрийг өнгөрүүлэв.

Ахлах дэслэгч Т.Алтантуул

ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн нээлтэд зориулсан тусгай төлөвлөгөөний дагуу нийт офицер, даргалах албан тушаалын ахлагч нартай заах арга зүйн цугларалтыг “Цэргийн сургалт бэлтгэлийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, зохион

байгуулах арга” сэдвээр зохион байгууллаа.

Уг үйл ажиллагааны хүрээнд ангийн даргалах албан тушаалтнууд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын харьяа 065, 337, 353 дугаар ангиудад ажиллаж харилцан туршлага солилцсон юм.

ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД...



Цэргийн алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг хангах, биеийн тамир, спортын ач холбогдол, үр нөлөөг нэмэгдүүлэх, гар

нийлэмжтэй нөхөрсөг хамт олныг бүрдүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн бөх, Монгол улсын өсөх идэр начин, ахмад Цэрэндашийн Цогтжаргалын

нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж, анги хамт олноороо дурсамж дүүрэн нэгэн өдрийг өнгөрүүлээ.

БАГА МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ БЭЛТГЭНЭ



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

2022 оны хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдсан дайчид цэргийн мэргэжил эзэмших сургалтдаа хамрагдаж байна. Тухайлбал, дайчдыг албанд нь богино хугацаанд дасгах, тэдний сэтгэл зүй болоод

бие бялдын ачаалал даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үе шаттай сургалт, арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд үргэлжлүүлэн цэргийн мэргэжил олгож, зэвсгийн бага мэргэжилтэн бэлтгэх хичээл, сургалтыг зохион байгуулж байна.

Ахлах дэслэгч Д.Даваажаргал

ГЭРЭЛ ЗУРАГ НЭГ АГШИН



ДЭЛХИЙН АВАРГА, МУГТ АХЛАХ ДЭСЛЭГЧ М.АНХЦЭЦЭГ АЗИЙН ТИВИЙН ХОШОЙ АВАРГА БОЛСОН ӨРГӨЛТ

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №14

Зарим онцлог зурлагын нийлэмж /үргэлжлэл/

Нуман зурлагат үсгийн дараа орсон гэдсийг нуман дотор нь эргүүлж /багтааж/ бичдэг.

Дармалаар:

Бичмэлээр:

